

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Ч.БАТ-ЭРДЭНЭ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
2016-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Улаанбаатар хот 2016

ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн хангамж, байршил:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь шинэчлэгдсэн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хүрээнд 5 албатай 74 хүний бүрэлдэхүүнтэй, эрүүл мэндийн эдийн засаг, үндэсний тооцоолол, эрүүл мэндийн удирдлага, нийгмийн эрүүл мэнд, сургалт, зайн анагаах ухаан, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм зүй, эрүүл мэндийн статистик, мэдээллийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнүүд ажиллаж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвд 2016 оны 8 дугаар сарын байдлаар төрийн үйлчилгээний 74 ажлын байранд 62 төрийн албан хаагч, гэрээгээр 12 хүн, хүүхэд асрах чөлөөтэй 5, нийт 74 хүн ажиллаж байна.

Үзүүлэлт		Тоо	Хувь	
Нийт ажиллагсдын тоо		74	100	
Хүйс	Эрэгтэй	16	21.6%	
	Эмэгтэй	58	78.4%	
Нас	21-29	17	22.9%	
	30-39	28	37.8%	
	40-49	23	31.0%	
	50-аас дээш	6	8.1%	
Боловсрол	Бүрэн ба тусгай дунд		7	9.45%
	Дээд	Бакалавр	37	50%
		Магистр	28	37.8%
		Доктор	2	2.7%
2016 онд сургалтад хамрагдсан байдал	Докторонтур		3	
	Магистрантур		8	
	Удирдлагын академи		2	

	Сертификат /богино хугацааны/			
	Үүнээс	Гадаад	16	
		Дотоод	33	
Мэргэжил	Хүний их эмч		17	
	Уламжлалт анагаах ухааны их эмч		6	
	Нүүр ам судлалын их эмч		3	
	Эм зүйч		8	
	Хууль, эрх зүйч		2	
	Ня-бо-эдийн засагч		5	
	ЭМ-ийн э/з		3	
	Мэдээллийн системийн Инженер		2	
	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер		6	
Нийт ажилласан хугацаа	Нийт	10 хүртэл жил	31	41.8%
		11-25 жил	27	36.4%
		25-аас дээш жил	6	8.1%
	Төрийн албанд	5 хүртэл жил	29	39.1%
		6 -10 жил	12	16.2%
		11-20 жил	23	31.0%
		21- ба түүнээс дээш	10	13.5%

Эдгээр үзүүлэлтийг албадаар гарган үзвэл :

№	Үзүүлэлт	ЗААА	МТЭТТА	СТСМА	ЭЗА	ЭМХА
Нас	21-29	2	5	3	3	4
	30-39	9	5	5	3	6
	40-49	9	2	4	1	7
	50-аас дээш	2	-	2	1	1
Дээд	Бакалавр	10	7	6	4	12
	Магистр	7	5	8	3	5
	Доктор	-	-	-	1	1
Төрийн албанд	5 хүртэл жил	10	7	3	4	5
	6 -10 жил	2	4	3	1	5
	11-20 жил	5	1	6	2	7
	21- ба түүнээс дээш	5	-	2	1	1

Эрүүл мэндийн удирдлагын тэргүүлэх зэрэгтэй-4, бусад мэргэшлийн -2, эрүүл мэндийн удирдлагын ахлах зэрэгтэй 7, статистикийн ахлах зэрэгтэй -2 нийт 13 албан хаагч мэргэшлийн зэрэг хамгаалсан байна.

Ажлын байрны шилжилт хөдөлгөөн сүүлийн 3 жилийн байдлаар авч үзсэн.

Тус төвд 2014 -2016 онд 36 албан хаагч шинээр ажилд орсон. Үүнээс :

2014 онд – 10, 2015 онд – 16, 2016 онд - 10 албан хаагч ажилд орсон. Энэ нь одоогийн нийт албан хаагчдын 48.6%-ийг эзэлж байна.

Харин энэ хугацаанд нийт 25 хүн ажлаас чөлөөлөгдөн, 4 хүн тэтгэвэрт гарч, 9 хүн хүүхэд асрах чөлөөг авсан.

2015 онд 11 хүн бүтцийн өөрчлөлтөөр, 3 хүн өөрийн хүсэлтээр, 1 хүн өөр ажилд шилжин ажиллахаар, 4 өндөр насны тэтгэвэрт гарсан тул тус тус ажлаас чөлөөлөгдсөн байна. 5 хүн хүүхэд асрах чөлөө авсан.

2016 онд 4 хүн өөрийн хүсэлтээр, 1 хүн өөр ажилд шилжин ажиллахаар, 1 хүн хүүхэд асрах чөлөөтэй хүний оронд ажиллаж байгаад чөлөөлөгдсөн. Шинээр 2 хүн хүүхэд асрах чөлөө авсан байна.

2015-2016 онд гадаад улс оронд магистрт суралцахаар 1 хүн чөлөө авч, 2 хүн ажлаас чөлөөлөгдсөн.

Насны байдлаар авч үзвэл нөхөн үржихүйн буюу 21-39 насны эмэгтэйчүүд 60.7% эзэлж байгаа бөгөөд 2014 онд 2 (ЭМХА-1, ЗААА-1), 2015 онд -5 (ЗААА-1, СТСМА-2, ЭМХА-1, МТЭТТА-1), 2016 онд -4 (ЭЗА-1, ЭМХА-1, МТЭТТА-2) албан хаагч хүүхэд асрах чөлөө авсан. Мөн 50-аас дээш насны 6 хүн байгаа нь ирэх 5 жилд тэтгэвэрт гарах магадлалтайг харуулж байна.

Сүүлийн 3 жилийн байдлаас харахад жилдээ дунджаар 10 албан хаагч шинээр ажилд орж буй тул цаашид одоо байгаа албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах боломжийг нэмэгдүүлэх, алба нэгж дотор сэлгэн ажиллуулах, гадаад хүний нөөцийн бүрдүүлэлтийг мөн шинээр сургууль төгсөж буй оюутнуудаас сонгон шалгаруулалт хийн авах шаардлага бий болж буй харагдаж байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар жилдээ 2-3 Удирдлагын академид, 3-4 хүн магистрын сургалтанд сурч буй тул энэ тал дээр дэмжлэг үзүүлэн ажиллахад 5 жилд албан хаагчдын 40-50% нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх боломж байна.

Одоо ажиллаж буй албан хаагчдаас магистрт суралцах хүсэлтэй 15, докторантурт элсэн суралцах хүсэлтээ 6 албан хаагч судалгаанд дурьдсан. Нийт ажилласан хугацаагаар нь авч үзэхэд 55.3% нь 10 жил хүртэл ажилласан албан хаагчид эзэлж байна. Залуу боловсон хүчнээр харьцангуй сайн хангагдсан байгаа ч судалгаанаас харахад сургууль төгсөөд ажиллаж байгаа нь дийлэнх нь байсан болохоор цаашид мэргэжлээр нь мэргэшүүлэх, магистрын сургалтанд хамруулах шаардлага гарч байна. Үүнээс үзэхэд цааш нь мэргэшүүлэх үү эсвэл мэргэшсэн боловсон хүчин олж авах уу гэдэг асуудал гарч байна.

Үүнийг яаж шийдвэрлэвэл байгууллагад үр өгөөжтэй талаар хүний нөөцийн сургалтын төлөвлөлтөнд тусгахыг зорьсон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ

2016-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа	Хугацаа					Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах эзэн, хамтрагч байгууллага	Шардагдах нөөц
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он				
Удирдлагын сургалтанд хамруулах	+	+	+	+	+	Ажилчдын удирдлагын талаарх ур чадвар, хандлага дээшилнэ.	Хамрагдсан ажилчдын тоо	ЭМХА Удирдлагын акедеми Бусад олон улсын байгууллага	
Гадаадын урт хугацааны сургалтанд хамрагдах ажилчдын тоог нэмэгдүүлэх, төгсөж ирээд байгууллагадаа ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах Жилд 1 хүн	+	+	+	+	+	Ажилчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар дээшилнэ.	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо Төгсөж ирээд байгууллагадаа ажилд орсон ажилтны тоо	ЗААА	ЖАЙКА, КОЙКА бусад байгууллагууд
Гадаадын богино хугацааны сургалтанд хамрагдах ажилчдын тоог нэмэгдүүлэх, шинэ мэдлэг, туршлага хамт олонтойгоо хуваалцах нөхцөлөөр хангах	+	+	+	+	+	Ажилчдын мэргэжлийн мэдлэг	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо Нэвтрүүлсэн ажлын тоо	ЗААА Бусад алба	ЖАЙКА, КОЙКА ОУ-ЫН байгуул лагууд
АШУУИС, ШУТИС болон бусад их дээд сургуулийн магистрантур, докторантурын сургалт жилд 2-3 хүн	+	+	+	+	+	Магистр, докторантур төгссөн албан хаагчдын тоо	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	ЗААА Бусад алба	

Удирдлагын академид суралцах Жилд 1-2 хүн	+	+	+	+	+	+	+	Удирдлагын академид суралцан төгссөн албан хаагчдын тоо	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	ЗААА Бусад алба	

Хянасан

Н.Нарангэрэл

Боловсруулсан

Г.Батцэцэг

